



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/44

Өмнөдэлгэр сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 48 дахь заалт, “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын 52 дахь заалт, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.6 дахь заалт, Засгийн газрын 2012 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 194 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлага, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын Газрын даргын 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 153 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2026 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний саналыг эрэмбэлж, төлөвлөх зорилго бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Оюунгэрэл

Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: С.Батсуурь

Төсөв, төрийн сангийн
мэргэжилтэн

Гишүүд: Х.Саруултуяа

Хөдөө аж ахуйн тасгийн дарга

Т.Эрдэнэтуяа

Нийгмийн бодлогын
мэргэжилтэн

Т.Чинхуяг

Байгаль орчны хяналтын улсын
байцаагч

Ё.Мөнх-Өлзий

Газрын даамал

Б.Хонгорзул

Иргэний төлөөлөл

2.Багуудын иргэдийн Нийтийн Хурлын тогтоолоор батлагдсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлж, нэгдсэн жагсаалтыг 07 дугаар сард багтаан боловсруулж ажиллахыг ажлын хэсэгт даалгасугай.



Р.ӨНХТӨР

2325310084

D:\disk\bichig\hereg-zahiramj\